

Шарын гол ХК-ийн ТУЗ-ийн 2012 оны  
..6...дугаар сарын 20... өдрийн хурлаар батлав



**ТУЗ-ийн хараат бус гишүүн, түүний үйл  
ажиллагаа явуулах журам**

**Улаанбаатар хот**

**2012 он**

## Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь ТУЗ-ийн хараат бус гишүүний тодорхойлолт, түүнд тавих шаардлага, бусад гишүүдээс ялгагдах онцлог, эрх, үүрэг зэрэг асуудлыг тодорхойлсон баримт бичиг болно.
- 1.2 Компанийн ТУЗ-ийн нийт гишүүдийн 1\3 нь хараат бус гишүүн байна.
- 1.3 Хараат бус гишүүн гэж ТУЗ-өөс гарах шийдвэр болон компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудалд хяналтын багцыг эзэмшигч, Гүйцэтгэх удирдлага болон төр ба орон нутгийн захиргааны байгууллага зэрэг компанийн үйл ажиллагаанд нөлөө бүхий оролцогч нараас хараат бус байж гагцхүү компанийн үндсэн эрх ашгийн үүднээс хандах үүрэг хүлээсэн гишүүнийг хэлнэ.
- 1.4 ТУЗ -ийн хараат бус гишүүн нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

### Хоёр. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх, томилох

2.1. Компанийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд компанийн дүрэмд заасан ТУЗ-ийн гишүүнд тавих нийтлэг шаардлагаас гадна дараахь шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлнэ. Үүнд:

2.1.1 өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

2.1.2 өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй;

2.1.3 төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

2.1.4 компанитай ТУЗ-ийн гишүүнээс өөрөөр бизнесийн аливаа холбоогүй.

2.2 Компанийн ТУЗ нь зөвхөн нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн хүнийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилуулахаар ХЭХ буюу түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэгч этгээдэд оруулж шийдвэр гаргуулна.

2.3 ТУЗ нь нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн хүнээс өөр хүний нэрийг дэвшүүлэхийг хориглоно.

### Гурав. Хараат бус гишүүний эрх, үүрэг

3.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ Үүнд:

3.1.1 төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл

ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэх зэрэгт хяналт тавих, энэхүү зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

3.1.2 компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

3.1.3 хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлэх

3.1.4 хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

3.1.5 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих.

#### **Дөрөв. Хараат бус гишүүнд тавих шаардлага**

4.1 Хараат бус гишүүн нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.1.1 Компанийн удирдлага, гол хувьцаа эзэмшигч, томоохон ороцогч болон компанийн өрсөлдөгч этгээдээс санхүүгийн болон бусад байдлаар хараат бус

4.1.2 Төрийн төлөөлөгч бус

4.1.3 Гүйцэтгэх удирдлагад үл оролцсон

4.1.4 Нөлөө бүхий хөрөнгө оруулагчаас / саналын 20 дээш хувийн эрхтэй ХЭ, ТУЗ-н гишүүн, Аудитор/ санхүүгийн болоод бусад зүйлээр хараат бус байх

4.1.5 Компантай хамтарч ажилдаг зөвлөгч биш байх

4.1.6 Өөрийгөө хараат бус хэмээн олонд зарласан байх

4.1.7 ТУЗ-д орж ажилласан хөлсөө зөвхөн компаниас авдаг байх

4.1.8 Шаардлагатай мэргэшил эзэмшсэн

4.1.9 ТУЗ-н хуралд тогтмол оролцдог

4.1.10 Олонд нэр хүндтэй

#### **Тав. Хараат бус гишүүний үйл ажиллагааны гол чиглэл**

5.1 Хараат бус гишүүн нь дараахь чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

5.1.1 Компанийн талаар үнэн бодит мэдээ мэдээлэллийг бололцоотой аргаараа түгээх.

5.1.2 Мэдээ мэдээлэл түгээхдээ бололцооны хирээр хувьцаа эзэмшигчдийн өргөн хүрээг хамруулах.

5.1.3 ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлын дотор цөөнх хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, илэрхийлсэн саналыг оруулах. Зөвлөлийн хуралдааны гол шийдвэрүүдийн талаар товч тайланг хурлын дараа хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын хүсэлтээр тавих

- 5.1.4 Мэдээллийг нээлттэй байлгах бодлогыг явуулах үүднээс хөрөнгө оруулагчдын сонирхсон асуултанд хараат бус гишүүн нь албаны болон арилжааны нууцыг хөндөхгүйгээр мэдээлэл өгөх
- 5.1.5 Цөөнх хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг сонирхлыг дараахь тохиолдолд хамгаалах Үүнд:
  - 5.1.5.1 Томоохон хэмжээний гэрээ хэлэцээр хийхэд
  - 5.1.5.2 Компанийг өөрчлөн байгуулах болон сонирхолын зөрчилтэй гэрээ хэлэцээр хийхэд зэрэг болно.
- 5.1.6 Өөрөө болон түүний гэр бүлийнхэн нь компанийн үнэт цаасаар арилжаа хийхдээ компанид мэдэгдсэн байх
- 5.1.7 ТУЗ-ийн гишүүнээр ажиллах явцдаа бие даасан захирлын байдалд нийцэхээ болих тохиолдолд даруй Зөвлөл, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх

oooOOOooo